

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДӨР ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-21
<hr/>	
1.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	4-11
2.Сонгуулийн ерөнхий хорооноос иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн явцын талаар мэдээлэл сонсох	6-21

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 4 дүгээр сарын 01-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 55 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ганбаатар, Ц.Туваан;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Э.Болормаа, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Ч.Номин, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ө.Шижир.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт А.Амармэнд, Б.Баясах нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир, гишүүдэд Улсыг Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Баярбаатар нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Сонгуулийн ерөнхий хорооны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн явцын талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт А.Амармэнд, Б.Баясах нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооноос иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн явцын талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Батбаатар, Б.Баярбаатар, О.Алтангэрэл, А.Ариунзаяа нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир хариулж, тайлбар хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Баярбаатар, А.Ариунзаяа нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн явцын талаарх Сонгуулийн ерөнхий хорооны мэдээллийг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 10 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 11 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 09 цаг 55 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Сандаг-Очир: Гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ТББХ-ны 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Баярмагнайн Баярбаатар, Жудгийн Баярмаа, Сандагийн Бямбацогт, Сархадын Зулпхар Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилигийн Лодойсамбуу, Лхагвын Мөнхбаатар, Эрдэнэбилигийн Одбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирж Байнгын хорооны хуралдааны ирц 53.1 хувьтай байна аа.

Ирцийг танилцуулж дууслаа. Алив гишүүдээ дуудаарай. Ирцэд орсон гишүүд хуралдааны танхимдаа.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгд, Байнгын хорооны тогтоолын төсөл ажлын хэсэг байгуулах тухай. ҮХЦ-ийн 12 дугаар дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулах.

Хоёрт, СЕХ-ноос ИТХ-ын нөхөн сонгуулийн явцын талаар мэдээлэл сонсох.

Гуравт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл. Монгол Улсын Ерөнхийлөгч 2026 оны 3 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг хэлэлцэх ёстой.

Гэхдээ хууль санаачлагчаас Ерөнхийлөгчийн Тамгын газраас өчигдөр аман байдлаар энэ хуулийг түр хойшлуулж өгөөч. Улсын Их Хурлын шинэ дарга томилогдохоор бас ярилцаж хэлэлцэж ойлголцох юмнууд байна гэсэн ийм асуудлыг ярьсан учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлуулж байна.

Мөн 4 дэх хэлэлцэх асуудал хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх ёстой. Мөн өнгөрсөн 5 дахь өдөр Ерөнхий сайд чөлөөлөгдсөнтэй холбогдуулж, Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон байгаа.

Тийм учраас энэ биелэлтийн тайланг танилцуулах айд томилогдоогүй байгаа учраас энэ хэлэлцэх асуудлыг ирэх 7 хоног руу болгож хойшлуулж байна. 4 дэх асуудлыг.

Ингээд 2 асуудал.

Байнгын хорооны тогтоолын төсөл, СЕХ-ноос ИТХ-ын нөхөн сонгуулийн явцын талаар мэдээлэл гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Байнгын хорооны тогтоолын төсөл, ажлын хэсэг байгуулах тухай хэлье.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн ТББХ-оос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101 дэх хэсэг, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн, гишүүд А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн, Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн.

2. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр эрдэмтэн судлаач, шинжээчид, холбогдох байгууллагын албан хаагчдыг татан оролцуулахыг ажлын хэсэг Сандаг-Очирт зөвшөөрсүгэй гэсэн байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй юу? Кноп нэрээ өг. Зулпхар гишүүн.

Зулпхар гишүүний микрофоныг өгье. Байж байгаарай микрофон чинь асаагүй байна.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Энэ Сандагаа дарга нэг зүйл тодруулах гээд байна. Энэ ҮХЦ-ийн дүгнэлт чинь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон Орон нутгийн сонгуулийн тухай хуультай холбоотой асуудал уу, өөр асуудал уу, мөн үү?

Ц.Сандаг-Очир: Дэг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101.1 Ерөнхий сайдыг огцруулах асуудал, 102.1 итгэл үзүүлэх эсэх асуудал гэсэн 2 асуудал Үндсэн хуультай зөрчилдчихсэн байгаа. 7 хоногийн дараа хэлэлцээд 10 хоногт багтаана гэдэг нь 3 хоногт хэлэлцээд 10 хоногт багтаана гэдэг Үндсэн хуультай зөрчилдөж байна гэсэн ийм Цэцийн 12 дугаар дүгнэлт байгаа. Тэгэхээр Дэгийн тухай хуулиа Үндсэн хуульд нийцүүлэх асуудал байгаа юм.

Өчигдөр бид нар хүлээд авчихсан тийм. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтад бэлдье. Ариунзаяа гишүүн гялс орчих.

Санал хураалт явуулъя. Сая танилцуулсан ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт гишүүд ээ. 19 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар санал дэмжигдлээ. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэж дууслаа.

10.06 цаг

Одоо 2 дахь асуудалдаа орьё. Ажлын хэсгийнхнийг оруулаарай.

Сонгуулийн ерөнхий хорооноос ИТХ-ын нөхөн сонгуулийн явцын талаар мэдээллийг сонсоно.

Алив албан тушаалтнуудын нэрийг. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Д.Даваа-Очир СЕХ-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нарийн бичгийн дарга. Д.Бат-Эрдэнэ СЕХ-ны Тамгын газрын дарга гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

СЕХ-ны мэдээллийг Хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Нарийн бичгийн дарга Даваа-Очир дарга танилцуулна. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Д.Даваа-Очир: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг эрье.

Аймаг сумын иргэдийн төлөөлөгчдийн 2026 оны нөхөн сонгуулийн тухай мэдээллийг та бүхэнд танилцуулж байна. СЕХ нь аймаг, нийслэлийн сум, дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуулийг жил бүрийн 6 дугаар сарын 3 дахь 7 хоногийн ням гарагт улс даяар нэгдсэн журмаар явуулна гэсний дагуу тус хороо 2026 оны 6 сарын 21-ний өдөр нөхөн сонгууль явуулахад бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна аа. Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн нөхөн сонгуулийн тухай хуулийн дагуу 2026 оны 3 сарын 16-ны өдрөө өдрөөс өмнө товлон зарлах бөгөөд хуульд заасан хугацаанд 16 аймгийн, 43 сумын нийт 73 хэсэгт нөхөн сонгууль явуулахаар товлон зарласан тогтоолыг тус хороонд ирүүлээд байна. Үүнээс 5 аймгийн 9 сумын 26 хэсэгт аймгийн ИТХ-ын 9 мандатад нөхөн сонгууль, 15 аймгийн 33 сумын, 44 хэсэгт сумын ИТХ-ын 39 мандатад нийт 48 мандатад нөхөн сонгууль явагдах болж байна аа.

Нөхөн сонгууль явагдах шалтгаан нь нөхцөл байдлыг авч үзэхэд нас барсан 14, хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 2, гэмт хэрэг үйлдэж, шүүхээр тогтоогдсон 6, тухайн орон нутгаас шилжсэн 2, төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон 6, төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсон шийдвэр нь хүчингүй болсон 3, өөр шатны ИТХ-ын төлөөлөгч 15 гэсэн шалтгаанаар төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон байна.

Тус хороо 2026 оны нөхөн сонгуультай холбогдуулан шаардагдах зардлыг Төсвийн тухай хууль болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын нөхөн сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу ангилал бүрээр тооцсон. Нийт 120 сонгуулийн хэсэгт нөхөн сонгууль явуулахад шаардагдах 4.9 тэрбум төгрөгийн төсвийн саналаа хүргүүлсэн боловч 55.4 хувиар бууруулан 2.1 тэрбум төгрөгөөр нөхөн сонгуулийн төсөв батлагдсан.

Дээр дурдсанаар хуульд заачихсан хугацаанд тухайн шатын хурлаас нөхөн сонгууль товлон зарласан аймаг сумын нийт 73 хэсэг нөхөн сонгууль явуулах шаардлагатай болж үүнд 814.5 сая төгрөгийн зардал дутагдаж байгаа юм аа. Аймаг, нийслэлийн сум, дүүрэг, иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас баталсан орон нутгийн хурлын ээлжит болон нөхөн дахин сонгууль байгуулахтай гарах зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс гаргана.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5.7-д ээлжит бус дахин нөхөн сонгууль ард иргэдийн санал асуулга явуулахад шаардагдах зардал гэж тус тус хуульчилсан юм аа. Иймд орон нутгийн Иргэдийн Хурлын төлөөлөгчдийн нөхөн сонгууль явуулахад шаардагдах 814.5 сая төгрөгийн нэмэлт зардлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага үүсэж байна аа.

Сонгуулийн хороо товлосон ёсоор нөхөн сонгуулийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллаж байгаа. 5 чиглэлээр 44 ажил энэ хуулийн хугацаанд нь хийгдээд явж байна. 4 сарын 12 гэхэд сонгуулийн хороодууд байгуулагдаад ингээд ажил жигдрээд явчих юм аа.

Товчхондоо би нөхөн сонгуультай холбоотой асуудлыг танилцуулж дуусаж байна аа.

Ц.Сандаг-Очир: Даваа-Очир даргад баярлалаа.

Хийсэн танилцуулга мэдээлэлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Зулпхар гишүүнээс эхэлнэ, микрофоныг өгье.

С.Зулпхар: Та бүхний өдрийн амгаланг дахин эрье. СЕХ-ны даргын үүрэг гүйцэтгэгчээс 1, 2 зүйл тодруулах гэсэн юм.

Нэгдүгээрт, одоо энэ 2 шатын сонгуульд оролцоод жишээ нь сумын ИТХ-ын төлөөлөгч болчихсон аймгийн Хурлын Төлөөлөгч болчихсон ийм нөхцөл байдлыг бид Орон нутгийн сонгуулийн тухай хуулиар хийчихсэн нэг ийм нөхцөл байдал байгаа юм. Энэтэй холбоотой ҮХЦ-ийн дүгнэлт гарчихсан. Энийг бол нийцүүлээрэй гэсэн. Энэ дээр энэ СЕХ судалгаа хийгээд их тодорхой байр суурь илэрхийлдэг байгууллага. Мэдээж сонгууль зохион байгуулахаас гадна сонгуулийн эрх зүйн орчинтой холбоотой. Энэ дээр та бүхний байр суурь ямар байгаа вэ? Цаашдаа бид ингээд ийм 2 сонгууль зэрэг ороод тэгээд хоёулаа тэнд гарчхаад тэгээд дараа нь мэдээж нэгийг нь сонгох ийм бас хуулийн зохицуулалт хийчхээд тэрнийхээ араас ахиад сонгууль зохион байгуулж төсвөөс ийм зардал гаргадаг эс үгүй бол сонгууль дахин зохион байгуулна гэдэг чинь бас өөрөө цаанаа захиргааны болон бусад зохион байгуулалт байгаа шүү дээ. Энийг яах вэ гэдэг нэг ийм асуулт байна. Энийг ер нь бид яах ёстой вэ?

Хоёр дахь асуулт болохоор зэрэг одоо бид ингээд сонгууль зохион байгуулахтай холбоотой бэлтгэлээ хангаж байгаа юм байна. Энэнтэй холбоотой энэ зүгээр мэдээж хэрэг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гарчих байх. Бусад захиргааны бэлтгэл нь хэр хангагдсан байна вэ гэдэг ийм асуулт байна. Захиргааны бэлтгэл өөрөө их тийм захиргааны байгууллага дээр дамжуулаад хангадаг зүйл шүү дээ. Энэ дээр ер нь бэлэн байдал хэр байгаа вэ гэдэг ийм 2 асуулт байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүний асуултад Даваа-Очир дарга ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Д.Даваа-Очир: Би 2 дахь асуултаас эхэлж хариулья.

Гишүүн бэлтгэл ажил хэр хангагдаж ажиллаж байна гэж. Ямар ч байсан бид бол цаг хугацааны хуваарьт нийцүүлээд ажлаа бол өнгөрсөн оноос эхэлж төлөвлөөд явж байгаа. Түрүүн би танд бас дурдсан 5 чиглэлээр 44 ажлыг бол ингээд хуваарьт ажилд оруулаад хүн болгон эзэнтэй орон нутагтаа хандчихсан. Ямар ч байсан ажил бол зохих журмын дагуу хуулийн хугацаанд явчихна. Ингээд 4 сарын 12-оос эхлээд сонгуулийн хороод байгуулагдчихна. Тэгээд бид бол сонгуулийн хороодтойгоо шууд харьцаад ажиллалчихдаг учраас энэ дээр бол бэлтгэл ажил бол хуулийн хугацаанд явж байгаа учраас энэ дээр янз бүрийн асуудлууд гарахгүй гэж би ойлгож явж байгаа.

Нэгдүгээр асуудал ер нь бол 2024 оны орон нутгийн сонгуулиар 8031 мандатад давхардсан тоогоор 78 иргэдийн хурлын төлөөлөгч давхардаж сонгогдсон. Өнгөрсөн онд бол бид 47 дээр нь сонгууль явуулаад аль нэг талд нь гарчихсан. Өнөөдрийн байдлаар бол 15 давхардал дээр бол нөхөн сонгууль явагдах гэж байна. Тэгээд ямар ч байсан хуулийнхаа дагуу нэгжийнхээ хуулийг бид бариад аль нэг нь дээр нь байх ёстой гэдэг зарчмаар явсаар байгаад өдий хүрсэн. Ямар ч байсан одоо бол нэг үлдэгдэл 16 давхардсан төлөөлөгч байгаа. Энэ дээр бол орон нутагтайгаа яриад ямар ч байсан асуудлуудыг бол тодорхой хэмжээнд шийдээд явж байгаа. Тэгээд бид бол орон нутгийнхаа сонгуулийн хуульд саяын цэцээс гарсан дүгнэлттэй холбогдуулаад өөрчлөлт оруулах саналуудаа явуулчихна.

Ингээд 2028 оны сонгуульд ямар ч байсан зөрчил гарахгүй нэг талдаа гараад явчихна аа. Ямар ч байсан мандат их олон байдаг оролцогч нэр дэвшигч нар их олон байдаг. 2024 оны сонгуульд бол 17248 нэр дэвшигчээс одоо 8031 мандатад иргэдийн хурлын төлөөлөгч нар маань сонгогдсон.

Ц.Сандаг-Очир: Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Түрүүн заримыг нь сонгууль явуулсан гэж байна. Одоо энэ 48 хүний иргэдийн Хурлын Төлөөлөгчийн эрхийг хэн дуусгавар болгосон бэ? Одоо жишээ нь шүүхийн шийдвэр ч юм уу өөрийн хүсэлт гэдгээр биш яг эцсийн шийдвэрийг СЕХ-оос тогтоол гарч байна. Иргэдийн Хурлын Төлөөлөгч нарын эрхийг нь дуусгавар болгож байна уу? Аль эсвэл орон нутгийн нутгийн удирдлагын байгууллага гаргаж байна уу, шүүх гаргаж байна уу гэдгийг асуух хэрэгтэй.

Хоёрт нь одоо Ерөнхийлөгчөөс өргөн баригдсан Их Хурлын гишүүнийг эргүүлэн татах тухай хууль өнөөдөр ТББХ-оор хэлэлцэгдэж байгаад Их Хурлын даргын томилгоотой холбоотойгоор 7 хоног хойшилж байх шиг байна.

Хоёр ч Их Хурлын гишүүнээс бас тийм хуулийн төсөл Засгийн газраас санал авахаар болчихсон. Одоо нэг 10 хоногийн дараа санал авах хугацаа нь дуусаад гишүүд Их Хурал руу ингээд өргөн мэдүүлчих байх.

Тэгэхээр үүн дээр тэр гишүүд эргүүлэн татагддаг бол энэ хуулиуд дээр СЕХ санал хуулийн төслүүдэд нь яаж саналуудаа өгч байгаа вэ? Тойргоос сонгогдсон, орон нутгаас сонгогдсон гишүүд тухайн орон нутагт нь бүсэд нь сонгууль явуулаад нөхөн сонгох байх. Намын жагсаалтаар орсон гишүүд эргүүлэн татагдвал дараагийн жагсаалт нь орно гэж байх уу, байхгүй юу. Үүн дээр та нар судалгаа лавлагаа гаргуулж байна уу? Нэг бол Цэц байна уу, шүүх байна уу? Үүн дээр сонгуультай холбоотойгоор ямар нэг тайлбар мэдээлэл одоо бэлдэж байгаа зүйл байгаа юу?

Гуравт нь Сонгуулийн ерөнхий хороо намуудын бүртгэлийг бас хариуцаж ажилладаг тайлан тооцоог нь авдаг, аудит хийдэг ийм болсон. Улс төрийн нам бол ТББ биш. Төрийн эрхийг авахын төлөө ардчилсан зарчмаар сонгуульд өрсөлдөж, иргэд сонгогчдоос дэмжлэг авч Улсын Их Хуралд сонгогдож орон нутгийн байгууллагад ингэж сонгогддог ийм тусгай субъект тусдаа хуультай. Улс төрийн намын нэрийг бариад хуурамч дарга цэрэг гардаг нь зөв юм уу. Үүн дээр та нар мэдэгдэл бүртгэлийнхээ дагуу юм хийдэггүй юм уу. 37 онц их хуралд уралдуулаад 37 намын чинь эрхийг авчаад сууж байвал юу болох юм бэ? Энэ Засгийн газраа хэрхэн бүрдүүлэх вэ гээд яриа хэлэлцээр нь явж байдаг. Энэ чинь илтэд хууль зөрчсөн хуулийн этгээдийн нэрийг барьж ашиглах чинь эрүүгийн ял шийтгэлтэй хэрэг шүү дээ. Үүнийгээ мэдэхгүй ингээд яваад байгаа зүйл дээр үг дуугардаг юм уу, дуугардаггүй юм уу.

Ц.Сандаг-Очир: Сонгуулийн хороо Улсын Их Хурлаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд бүх шатын сонгуулийг зохион байгуулах л үүрэгтэй. Тэгээд ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Д.Даваа-Очир: Гишүүний асуултад хариулъя аа. Тэр одоогийн явагдах гэж байгаа мандат дээр дуусгавар болсон холбоотой асуудал ярилаа. Бид бол тэр дуусгавар болсон асуудлыг хуулийн хүрээнд нь шийдсэн. Тогтоолын дагуу бол энэ нөхөн сонгуулийг бол товлон зарлаж явуулж байгаа. Ингээд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41.1-д заасны дагуу төлөөлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон гэдэг ангиллаар өөрөөр хэлэх юм бол нас барсан 14 байна.

Хүндэтгэх үзэх шалтгаанаар чөлөөлөх хүсэлтээ гаргасан 2, гэмт хэргийн улмаас шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон 6, тухайн орон нутгаас шилжсэн 2, төрийн албанд томилогдсон 2, гэх мэтийн мандатаар дуусгавар болсон.

Тийм учраас орон нутгаас хурал нь шийдээд тогтоол ирүүлсэн. Энэн дээр бид үндэслээд явж байгаа. Судалгааг бол бидэнд тогтмол байдаг. Энэ судалгаан дээрээ үндэслээд энэ ажлыг шийдээд явж байгаа гэж ойлгоорой. Тэр намын бүртгэлтэй холбоотой асуудлууд ярьж байна. Зүгээр бидэнд одоо өнөөдөр бол бараг 37, сая 1 нам нь нэмэгдээд 38 нам бол өнөөдөр Дээд шүүхэд бүртгэлтэй байна.

37 намаас одоо яг Дээд шүүхээс дүрэм журам нь батлагдаад ирсэн 9 нам байгаа. Бусад нам нь бол Дээд шүүх дээр процессын ажлууд нь явагдаж байгаа учраас бусад намын талаараа бол бидэнд мэдээлэл алга. Тэгээд намын бүртгэл

аудит бол хуулийн дагуу явж байгаа. Төрийн аудит орно. Хараат бус аудитууд орно. Манай хяналт ингээд явж байгаа. Иргэдийн хяналт энэ дээр байдаг учраас бид бол өөрийнхөө сайтаар бол байнга тавьж байдаг. Энэ дээр бол харин намууд ч бидэнтэй их хамтарч зөв зүйтэй гаргалгаа олж хамтарч ажиллаж байгаад бас бид бол баярлаж хамтарч ажилладаг ийм тогтолцоо руу бол нэгэнт орсон гэдгийг бас та бүхэнд танилцуулъя.

Ц.Сандаг-Очир: Батбаатар гишүүн нэг минут тодруулга.

Б.Батбаатар: Ерөнхийлөгчийн Улсын Их Хуралд өргөн барьсан хууль дээр санал өгсөн болов уу үгүй болов уу гэдгийг дээрээс нь бас нөгөө сонгууль зохион байгуулж байгаа мэргэжлийн байгууллагынхаа хувьд, хараат бус байгууллагынхаа хувьд бас Улсын Их Хурлаар та бүхний ажилтай холбоотой хууль хэлэлцэж байхад өөрсдөө бас санаачилгаараа санал эд нар өгдөг тийм боломж уг нь байгаа гэж ойлгоод байгаа юм би. Тийм зүйл өгсөн үү, үгүй юу гэдгийг.

Ц.Сандаг-Очир: 4 номерын микрофон.

Б.Батбаатар: Нөгөө хуулийн төсөлд бидэнд бол санал өг гэж хүсэлт ирээгүй. Бид бол санал өгөөгүй байгаа. Ер нь ингээд Ерөнхийлөгчийн сонгууль ойртчихлоо. Их Хурлын сонгууль ч дөхөж байна. Ер нь бол бид Ерөнхийлөгчийн сонгуульд бол Бум-Очир гишүүнтэй ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ дээр бол саналаа өгөөд явж байгаа. АН дээр манай удирдлага 12 сард мэдээлэл өгөөд АН-ын гишүүдээс Батсуурь гишүүн ахалсан бас Улсын Их Хурлын сонгууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал явж байгаа. Тэрэн дээр бид саналаа өгөөд явж байгаа. Энэ дээр бол манай Сонгуулийн хороо идэвхтэй ажиллана. Энэ дээр уул нь гол гол нь бол урьдчилсан санал авах нөгөө санал хаягддаг бүлэг улсууд байгаа. Жишээлэхэд уул уурхай ложистикийн компаниудад ажиллаж байгаа оюутнууд мөн одоо.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ.

СЕХ-ны мэдээллээс ч асуулт бол ер нь байхгүй ээ. Одоо зүгээр тэгээд нэгэнт л үүсчихсэн нөхцөл байдал юм чинь тэгээд сонгуулиа зохион байгуулаад явах болов уу гэж харж байна. Зүгээр энэ нөгөө ардчилсан нийгэмд шилжээд бид чинь 9 удаагийн Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийг янз бүрийн тогтолцоогоор зохион байгуулсан. Зүгээр энэ дотроос ингээд үзэхэд өнөөдөр одоо жишээлбэл энэ мэдээлэл дотор энэ хууль хоорондын уялдаагүйгээс болоод энэ татвар төлөгчдийн мөнгөөр ингээд дахиж сонгууль хийх гэж байгаа асуудлууд нь 50 хувь нь байж байгаа байхгүй юу. Мэдээж амьдрал баян хорвоогийн мөнх бусыг үзүүлж байгаа, янз бүрийн шүүхийн шийдвэрээр энэ тэр гэсэн олон зүйлүүд байгаа.

Тэгэхдээ эндээс ингээд яг статистикийг нь ингээд үзэхээр чинь яг энэ нөгөө аймгийн иргэдийн хурал, сумын иргэдийн хуралдаа давхар нэр дэвшээд хоёуланд нь сонгогдчихсон тэгээд хоёуланд нь байж болохгүй учраас аль нэгийг нь сонгож авч үлдээд үлдсэн дээр нь ингээд сонгууль зарлаж байгаа. Энэ чинь 50 хувь нь байж байгаа. Тэгээд эдгээр зүйлүүд бид нар энэ 2024 онд болсон Орон нутгийн сонгуулийн хуулийг шинэчилж чадаагүй орчихсон юм л даа. Тэгээд одоо энэ орон нутагт чинь яг бодит байдал дээрээ тэгээд л улс төрийн намаас өөр улс төрийн нам руу орох янз бүрийн байдлаар тэрний цаана албан тушаалын хүртэл тохиролцоо

хийх эд нар гэсэн зүйлүүд бодитойгоор явж байдаг. Энэ дээр энэ хуулийн ажлын хэсгээ эртхэн байгуулаад асуудлаа яримаар байгаа юм.

Дараагийн асуудал нь энэ сумын иргэдийн хуралд чинь ер нь яг ний нуугүй хэлэхэд хамгийн олон ах дүү хамаатан садантай л сонгогддог юм шүү дээ. Тэгээд тэрэн дотроос яг бас сумынхаа хурлын дарга, Засаг дарга хийчих боломж бололцоотой хүмүүс нь их цөөхөн.

Цаашид ер нь энэ суманд чинь бас энэ нутгийн өөрөө удирдах ёсыг дэмжих ёстой. Тэгэхдээ энэ сумд яг ийм сонгууль явуулдаг энэ улс төржилтийн асуудлыг бууруулахгүй бол хамгийн их улс төрждөг газар орон нутаг байдаг шүү дээ. Анхан шатандаа. Тэгэхээр сонгуулийн хороо ер нь та бол сая хэллээ. Энэ сонгууль дөхчихлөө. Улсын Их Хурал орон нутгийн сонгууль дөхчихлөө ч гэж хэлж байх шиг байна. Тэгэхээр ер нь заавал энэ Их Хурал гэдгээс хамааралгүйгээр ер нь энэ шинжлэх ухааны үндэстэй олон талт судалгаануудыг хийж байгаа байх гэж би найдаж байгаа. Тэгээд тэрийгээ бидэнд танилцуулаад ийм байна. Ер нь ийм нөхцөл байдлаар явахгүй болохгүй байна. Бид бол хөдөө орон нутаг янз бүрийн байдлаар ажиллаж байгаа учраас яг болж байгаа процесс нөхцөл байдлыг бол газар дээр нь юу болоод байгааг бид нар маш сайн мэдээлэлтэй байгаа, маш сайн мэдээлэлтэй байгаа. Ингэж тал талаасаа нийлж байж одоо энэ 2028 онд болох Улсын Их Хурал орон нутгийн сонгуулийн асуудал дээр хуулиа маш чамбай эртнээс.

Ц.Сандаг-Очир: Нэг минут тодруулга.

Б.Баярбаатар: Байгаа гэдгийг бас хэлмээр байна. Тэгээд энэ эдийн засаг хүнд байна. Өнөөдөр энэ тэтгэвэр ахмадын тэтгэвэр энэ төрийн албан хаагч, багш эмч, нарын цалингийн асуудал гээд л нөхцөл байдал хүнд байхад дээр нь бид нар энэ үндсэндээ энэ нөхөн сонгуульд ингэж 800 гаран сая төгрөг зарцуулна гэдэг нэг бол нэг ёсондоо шулуухан хэлэхэд үр дүнгүй зардал байхгүй юу. Тэгээд үнэхээр ингээд энийг нөхөн сонгохгүй бол тэр сумын иргэдийн хурал нь, аймгийн иргэдийн хурал нь үйл ажиллагаа явуулж чадахгүй юм бол зогсох гээд байгаа хэмжээнд оччихоод байгаа нь бас нэг хэрэг. 816 сая гэнэ ээ. Тэгэхээр эдгээр зүйлүүд дээр ер нь эргэж нэг харах, бодох ёстой юм байна аа. Сонгуулийн хороо энэ дээр бас нэг тодорхой судалгаанууд ер нь хийж байгаарай. Хэдүүлээ хамтраад энэ дээрээ сууцгаана шүү гэдгийг би бас зүгээр саналын байдлаар хэлье.

Ц.Сандаг-Очир: Үг хэллээ. Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн болон сумын ИТХ-тай сонгуультай холбоотой нэг асуух зүйл бага байна аа. Ирэх жил Ерөнхийлөгчийн сонгууль болох гэж байна. 2 жилийн дараа Улсын Их Хурлын сонгууль болно. Тэгээд энэ сонгуулийн зохион байгуулах төсөв нөгөө асуудал гараад байдаг хар машины маань хүрэлцээ ер нь хугацаа нь дуусаж байна, ашиглалтаас гарч байна гэж ингэж ийм мэдээлэл авч байсан. Одоо ер нь энэ хүрэлцээ нь ямар байна вэ? Яг энэ том сонгууль зохион байгуулахад ер нь бэлэн байна уу? Ер нь тулаад биш наана нь бэлтгэлээ хангахад ямар хэмжээний төсөв хөрөнгө шаардлагатай байна? Яг өнөөгийн байдлаар энэ төрийн том сонгууль зохион байгуулахад техникийн болоод хөрөнгө санхүүгийн хүчин чадал чинь ямар байна вэ гэсэн ийм асуулт байна.

Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Д.Даваа-Очир: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Бид 2012 оноос хойш 38 ээлжит нөхөн, дахин сонгуульд 38 сонгуульд үндсэндээ санал тоолох төхөөрөмжийг бол ашиглагчаад байна. 2012 оноос хойш. Бидэнд бол та бүхэн мэдэж байгаа байх 3 мянган санал тоолох төхөөрөмж байдаг. Бид бол үүнээсээ 1 257-г нь акталчхаад байгаа. Өнөөдрийн байдлаар 473 санал тоолох төхөөрөмжийг засварт явж байгаа. Яг одоо бэлэн байгаа нь бол 2 мянга гарантай. Бид өнгөрсөн онд бол ерөнхийдөө санал тоолох төхөөрөмжөө дараагийн загвараар нь бүрэн шинэчилье. 3 мянган ширхгийг зайлшгүй авах шаардлагатай байна гэдэг асуудлаар төсөвт тавиулаад үүнээс 12.5 тэрбум төгрөг өнөөдрийн байдлаар бол 940 ширхэг санал тоолох төхөөрөмж авах мөнгөтэй байгаа. Урьд нь бол бид ер нь ингээд олон сонгуулийг өнгөрөөлөө.

Ер нь ингээд 2026 ондоо санал тоолох төхөөрөмжөө шинэчилье гээд 41.7 тэрбум тавьсан боловч үүнээсээ хасагдаад 30 хувийг нь л авсан л даа. Үндсэндээ 70 хувь нь хасагдчихсан. Үлдэгдэл 29.2 тэрбум төгрөгийг бол үндсэндээ 2026 оны төсөв яах нь вэ, 2027 онд яах нь вэ, 2028 онд яах нь вэ ингээд Сангийн яам маань бол цувруулж өгье гэсэн ийм байдлаар бол бидэнд хэлсэн. Бид бол санал тоолох төхөөрөмж нийлүүлдэг байгууллагатайгаа яриад үндсэндээ энэ асуудлаас өмнө бэлтгэл ажлаа хангаад энэ ондоо техник хэрэгслээ шинэчилье гэсэн байр суурьтай үйлдвэрлэгч компанитайгаа ярьсан боловч мөнгөний асуудлаас болоод энэ бол ингээд хойшлох гээд байна. Бид бол бас төсвийн тодотгол гарах юм бол энэ 29.2 тэрбум төгрөгийн асуудлыг тавиад чадвал энэ ондоо багтаагаад техник хэрэгслээ шинэчилчих юм бол 2027 оны сонгууль, 2028 оны орон нутгийн болон Их Хурлын сонгуульд Сонгуулийн хороо бол сонгууль авах үйл ажиллагааг бүрэн хэвийн явуулчихна гэсэн ийм итгэл үнэмшилтэйгээр өнөөдрийг хүртэл бол ажиллаад явж байгаа. Яах вэ одоо ингээд Ай Си Пи нэг төхөөрөмж 2012 онд авсан. Бид бол явцын дунд би түрүүн та бүхэнд хэллээ. 757-г нь шинэчилчихсэн Ай Си Пи 2 гэдэг төхөөрөмж ороод ирсэн. Ингээд яваад байх юм бол бидний ямар ч байсан техникийн шинэчлэлийн ажил явчих юм бол сонгууль явуулахад цааргалаад хүнд хүчир нөхцөл байдал үүсэхгүй байх гэж бодож байгаа.

Хэрвээ энэ 2026 онд энэ 3 мянган санал тоолох төхөөрөмжөө бид авчих юм бол сургуулилт хийдэг, суралцдаг, ай ти улсуудаа орон нутагт нь сургадаг. Ингээд явах юм бол эрсдэл бол байхгүй нөхцөл байдал үүсчихнэ гэж та бүхэн ойлгож болно оо.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Ингээд л Улсын Их Хурлын гишүүдийн л буруу болж таарч байгаа байхгүй юу. Сонгуулийн тоног төхөөрөмж авах төсөв шаардлагатай байна гээд оруулж ирэхэд 70 хувийг нь хасаж өгөөд л 30 хувийг нь баталж өгчхөөд л тэгээд л бэлтгэлээ хангасан уу гээд л асуугаад л сууж байгаа юм. Тэгээд яах вэ бас улс дан Улсын Их Хурал гэхээсээ ч илүүтэй ер нь шинэ Ерөнхий сайд, одоо магадгүй шинэ Сангийн сайд нэг төсвийн тодотгол хийхээс өөр арга байхгүй гэдэгтэйгээ нүүр тулж төр хүлээсэн үүргээ хүлээж одоо энэ тавих ёстой төсвүүдээ тавьж өгөөсэй өгөөрэй. Улсын Их Хурлын буруу ч гэж юу яахгүй Засгийн газрын л бодлого шүү дээ. Улаан, ногоон лазераар ч гэсэн бас яаж төсөв баталлаа. Хэрэгцээтэй хэрэгцээгүй зөндөө л мөнгө тавьсан шүү дээ. Энэ дээр анхаарч нэг төр хийх ёстой ажлаа хийнэ байгаа. Энэ аймаг нийслэлийн яг энэ сонгуультай холбоотой тулгамдаад байгаа асуудлын нэг нь бас л дахиад л нөгөө нэг Улсын Их Хурлын өөрийнх нь л буруу болж таарч байгаа байхгүй юу. Өчигдөр бид ҮХЦ-ийн дүгнэлтийг 11 дүгээр

дүгнэлтийг хэлэлцсэн. Яг энэ засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт.

Үндсэн хуульд нийцсэн нийцээгүй гэдэг маргаан дээр Үндсэн хуульд нийцсэн байна. Үндсэн хуульд нийцсэн байна, зөрчөөгүй байна гэдэг ийм шийдвэр гаргасан. Тэгээд энэ 40.1.2 нь өөрөө юу юм бэ гэхээр шат шатын иргэдийн Хурлын Төлөөлөгч байж болохгүй гээд заагаад өгснийг бол маргаан үүсгэсэн байгаа. Тэгээд энийг хэн үүсгэсэн бэ гэхээр 2 шатдаа мэдээж сонгогдсон байгаа төлөөлөгчийн зүгээс л эрх ашгаа хамгаалахын тулд энэ маргааныг үүсгэсэн байгаа шүү дээ. Яагаад гэхээр Орон нутгийн сонгуулийн тухай хуулиар энэ эрх нь нээлттэй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд одоо яг яаж байна вэ гэхлээр зарим үзээтэй нөхдүүд нь болохлоор хэвээрээ аль аль хуралдаа хэвээрээ байгаад байгаа. Энэ хууль нь хэвээрээ байгаа юм чинь. Зарим нэг нь бол хүчгүй нэг нь бол аль хэзээний хүчингүй болгогдоод нөхөн сонгууль зарлагдаад явчихсан.

Дунд нь байгаа нөхдүүд буюу яг энэ 15 хүний бол энэ давхар сонгогдсон 15 хүний нөхөн сонгууль нь бол энэ 6 сард зарлагдах юм байна аа. Цаана нь давхар гэхдээ үлдчихсэн байгаа нэлээд хэсэг бас хүмүүс байгаа юм байна үзээтэй байгаа. Тэгэхээр энийг яаж шийдвэрлэх вэ гэдэг ийм асуудал байгаа байхгүй юу. Тэгээд энэн дээр ҮХЦ-ийн шийдвэрийг бид нар хүлээгээд авчихсан юм чинь Хууль тогтоомжийн тухай хуулиар тавигддаг шаардлагуудыг биелүүлэхгүйгээр зүгээр богино хугацаанд энэ хуулийн зөрчлийг арилгаж болох уу, үгүй юу?

Ц.Сандаг-Очир: Нэг минутын тодруулга Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Тэгэхээр санал юу байна вэ гэхээр нэгэнтээ бид нар өчигдөр энэ ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээгээд авчихсан учраас хууль хоорондын зөрчлийг арилгах үүднээс маш богино хугацаанд ТББХ-оос ажлын хэсэг гаргадаг санж уу, эс үгүй бро ТББХ өөрөө энэ хуулийн төслийг өргөн барьдаг санж уу? Яг энэ Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн тэр тухайлсан зөрчил үүсгээд байгаа заалтыг хүчингүй болгох ийм богино ганцхан өгүүлбэртэй хуулийг оруулмаар байна аа. Тэгэхгүй л бол нийтэд нь энэ Сонгуулийн тухай хуулийг өөрчилнө гээд ердөөсөө энэ асуудлуудаа цэгцлэхгүй ингээд орхичоод байгаа нь эргээд сонгогдсон болон одоо энэ сонгуульд оролцох гэж байгаа хүмүүст бол маш шударга бус байдлыг үүсгээд байгаа байхгүй юу. Хууль нь ердөөсөө өөрчлөгдөөгүй байгаад байна.

Тэгэхээр энэ 6 сараас өмнө нэн яаралтай энэ сонгуулийн энэ хуулийг нь өөрчлөх шаардлагатай. Уг нь бол тэгээд аливаа хууль нөхөж хойшоогоо үйлчилдэггүй л юм байгаа юм. Тэгэхээр ингээд л бас л асуудалтай байгаа байхгүй юу.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүний асуултад 4 номерын микрофон.

Д.Даваа-Очир: Гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар бол нөхөн сонгууль зарлаагүй 8 сумын 16 давхардсан төлөөлөгч л байна л даа. Тэгэхээр үлдчихсэн байгаа нь. Тэгэхээр энэ дээр бол ингээд Цэцийн зүгээр сонгуулийн хороо бол ийм шийдвэр гарсан. Энэ асуудлыг хууль дүрмийнхээ хүрээнд цэгцлэх ёстой шүү гэдэг иргэдийн хуралд нь л шаардах эрхтэй. Тэгээд иргэдийн хурал орон нутаг асуудлаа өөрөө шийдээд явчихдаг. Нэгэн бол татгалзуулах юм уу, уяах юм энэ тэр гэдгээ ямар ч байсан бид өөрийнхөө хуулийнхаа хүрээнд энэ шаардлагаа бол хүргүүлнэ. Тэгээд хурал маань яаж шийдэхийг бид мэдэхгүй байгаа. Ер нь бол 2023

оны сонгуульд орон нутгийн нөхөн сонгууль болохоос өмнө ийм зөрчил байна гээд бид хуулийн орон нутгийн хуульд өөрчлөлт оруулъя гэдэг саналаа бол Сонгуулийн хороо өргөн барьсан шүү дээ. Тэгээд нөгөө цаг хугацааны хайчинд ороод тэр маань батлагдаагүй. Ингээд ийм л үр дагаварт л хүрээд байгаа юм л даа. Тэгээд яах вэ 2028 оны орон нутгийн сонгуульд энэ үр дагаврууд энэ зөрчлүүд бол арилчих байх гэж бодож байгаа. Бидний санал бэлэн байгаа.

Ц.Сандаг-Очир: Нэмэлт нэг минут Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Сонгуулийн хорооноос биш би Сандаг-Очир дарга би танаас асуугаад байгаа байхгүй юу. Бид одоо яг энэ Цэцийн дүгнэлтийг хүлээн авсантай холбоотойгоор тэд хоногийн дотор хуулийн зөрчлийг арилгах тэр заалтыг ашиглаж болох уу? Яг энэ тухайлсан ганцхан энэ заалтын зөрчлийг энэ богино хугацаанд арилгаж болох ийм гарц гаргалгаа байна уу? Эс үгүй бол ийм гарц гаргалгаа байхгүй бол энэ Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг тэр Хууль тогтоомжийн тухай хуулийн тавигдах шаардлагуудыг нийцүүлж байж батлах ёстой юу эс үгүй цэцийн дүгнэлттэй холбоотойгоор яг тухайлсан тэр Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн энэ зөрчил үүсэх гээд байгаа тус заалтыг дангаар нь хүчингүй болгох энэ асуудлыг яаралтайгаар Улсын Их Хуралд оруулж болох уу, ийм гарц гаргалгаа байна уу.

Ц.Сандаг-Очир: Цэцийн дүгнэлттэй холбоотойгоор яаралтайгаар гэсэн юм бол байхгүй. Та өөрөө хууль санаачлагчийнхаа хүрээнд хууль санаачлаад боловсруулаад ороод ирэх бололцоо боломж хуулиар байгаа. Яг хууль хоорондын зөрчлөөс болж энэ нийтдээ нэг 48 мандатаар сонгууль болох гээд байна. Аймгийн 9, сумын 39. Энэн дээр 15 мандат дээр болох сонгууль бол ер нь хууль хоорондын зөрчлөөс үүдэлтэйгээр сонгууль болох гэж байна тийм үү? Сонгуулиар ерөнхий хороонд. 2 нь аймаг дээр. Үндсэндээ 13 сум дээр. Нэг бол аймгийнхаа иргэдийн Хурлын Төлөөлөгчийг нэг нь сонгож байгаа. Нэг нь нөгөөдөх нь сумынхаа иргэдийн хурлын төлөөлөгчийг сонгож байгаа. Тэгээд ямар ч гэсэн бид нар та бол дахин сонгууль нөхөн сонгууль явуулахгүйгээр наана нь хуулиа засаад энэ заалтыг өөрчлөөд нөхөн сонгууль явуулахгүй байх асуудлыг ярих гээд байна тийм үү? Би тэгж ойлголоо зөв үү, үгүй үгүй юу?

А.Ариунзаяа: Тэр чинь дараагийн асуудал.

Ц.Сандаг-Очир: Тэр чинь дараагийн асуудал шүү дээ. Та ахиад нэг тодруул даа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр одоо хууль өөрчлөгдөөгүй зөрчил хэвээрээ байгаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүтээ нөхөн сонгууль зарлах гээд байгаа байхгүй юу. Гэхдээ хууль чинь зөрчилтэй хэвээрээ байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө буруу. Ийм учраас би хэдийгээр гишүүний хувьд энийг санаачилж болох боловчиг гишүүнийхээ хувиар үүнийг хийхлээр Хууль тогтоомжийн тухай хуулийг дагаж тэд хоног байршуулаад, тэрнээс санал аваад, хэлэлцүүлэг хийгээд ингээд удах гээд байгаа байхгүй юу. Нэгэнтээ бид нар өчигдөр Цэцийн энэ дүгнэлтийг хүлээгээд авчихсан юм бол тэрэнтэйгээ яах вэ мэдээж нөгөө цэцийн дүгнэлт нь өөрөө зөрчилтэй байна гэж дүгнээгүй ч гэсэн зөрчилтэй гэж дүгнэх юм бол бид нар энийг арилгах ёстой болчихно шүү дээ тийм үү Үндсэн хуулийн зөрчилтэй гэвэл. Гэтэл энэ Үндсэн хуулийн зөрчилгүй байна. Гэхдээ өөр ийм хуулийн зөрчил байна гэдгийг дүгнээд өгчихсөн учраас тэр агуулгаараа Хууль тогтоомжийн тухай хуулийн процедур шаардлагыг авахгүйгээр

энэ цэцийнхээ ажлын хүрээнд энэ орон нутгийн тэр тэр зөрчилтэй байгаа хуулийг өөрчлөөд өгч болохгүй юм уу гэдгийг л асуугаад байна.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн энэ шүү дээ. Нэгжийн хуулийн хориглосон заалт чинь Үндсэн хууль зөрчөөгүй гэж гарсан шүү дээ. Үндсэн хууль зөрчөөгүй. Гомдол гаргагч бол нэгжийн хуулийн 40.1 байхаа хориглочихсон. Орон нутгийн сонгуулийн хуулиар нээлттэй байсан. Тэгээд гомдол гаргачихвал цэц дээр энэ хориглосон заалт нэгжийн хуулийн хориглосон заалт Үндсэн хууль зөрчсөн гэдэг маргаан үүсгэсэн байхгүй юу. Цэц бол энэ заалт бол Үндсэн хууль зөрчөөгүй байна гэдэг маргаан гаргачихсан.

Сонгуулийн хуулиар зөвшөөрөгдөөд тэрний дагуу нэр дэвшээд давхар сонгогдчихсон. Тэгээд тэрийг бид нар Сонгуулийн хуулийг одоо нэгжийн хуультайгаа нийцүүлж өөрчлөх асуудал Цэцийн дүгнэлттэй холбогдуулж гарч байгаа зайлшгүй. Тэгэхгүй бол 2 хуулийн зөрчил үүсчхээд байгаа шүү дээ. Тэрийгээ тэгээд засаад явах нь бол бид нар Их Хурлын үүрэг, орон нутгийн сонгуулийн. Одоо гэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар Сонгуулийн хороо сонгуулийн бэлтгэл ажлыг хангана. Одоо 4 сарын хэднээс билээ хэсгийн хороодуудаа 12-оос авхуулаад хэсгийн хороодууд байгуулаад явах учраас цаг хугацааны хувьд бол боломжгүй байгаа. Одоо бид нар хэзээ хуулиа өргөн барьж санаачлаад хэзээ Улсын Их Хурал оруулаад ингээд явах вэ гэхээр 12-ны дотор амжихааргүй байгаа тийм үү?

Тийм учраас энэ сонгуулийн нөхөн сонгуулийн юмнууд тэртээ тэргүй явдгаараа явахаас аргагүй болж байгаа. Гэхдээ бид нар энийг Сонгуулийн хуулиа засахаас өөр аргагүй байгаа шүү дээ. Ер нь засах ёстой.

Өнөөдөр ТББХ-оор энэ сонгуулийн хорооны мэдээллийг сонсож байгаа асуудал нь 2, 3 талын асуудал байгаа юм аа. Байнгын хорооны гишүүдийн анхааралд оруулах гэж.

Нэгд тулчихсан байгаа нөхөн сонгуулийн энэ 48 мандат дээр аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгууль явагдах гээд 4 сарын 12-оос хэсгийн хороодууд байгуулагдах гээд ингээд яв явж байгаа. Нэгд төсөв дутаж байгаа. 814 сая төгрөгийн төсвийн асуудал яригдаж энийг 14 хоногийн өмнө тухайн үеийн Занданшатар даргад Засгийн газрын нөөц сангаас энэ асуудлыг шийдэж өгөөч гэдэг албан тоотыг СЕХ-ны албан тооттой хамтдаа ингээд Байнгын хорооны даргын үүднээс явуулсан байгаа. Энийг нэгд шийдэх асуудал байгаа.

Хоёрт сонгуулийн хорооны гишүүд буюу нийт 9 гишүүнтэй 2 нь орон тооны 7 нь орон тооны бус гишүүд байгаа. Гэтэл 7 орон тооны бус гишүүдийн бараг тэр чигээрээ 6, 7 бараг бүгдээрээ байна уу? Бүрэн эрх нь дуусчихсан, албан тушаал нь өөрчлөгдчихсөн тэрийг нэг та Даваа-Очир дарга нэг хэлээдэх.

Яг сонгуулийн хорооны гишүүд чинь орон тооны бус гишүүд чинь хэд нь байна, хэд нь албан тушаал өөрчлөгдчихөв гэдэг энэ асуудлууд байгаа. Энийг бид нар яаралтай шинэ Их Хурлын дарга томилогдоод энэ асуудлыг нэг тийш нь болгохгүй бол Сонгуулийн хороо чинь өөрөө бас бүтэц бүрэлдэхүүний хувьд бэлэн биш байна аа. Ерөнхийлөгчөөс санал болгодог орон тооны бус гишүүн байна. Дээд шүүхээс санал болгодог орон тооны бус гишүүн байна. ТББХ-оос санал болгодог гишүүд байна гээд ингээд. Энийг та нэг хэлээдэх. Хэчнээн хүн Сонгуулийн хорооны гишүүдийн орон гарсан асуудлууд байна вэ гэдгийг.

Гуравт бол Ерөнхийлөгчийн сонгууль. Хар машины асуудал. Ингээд сая ярьж байхад бол үндсэндээ дийлэнх олонх нь актлагдчихсан байна аа. 2026 оны төсөвт өнгөрсөн жил, өнгөрсөн намар СЕХ-оос саналаа өгсөн. Харамсалтай нь Сангийн яам төсвийг нь хассан. 3-ны нэгийг нь шинэчлэх төсвийг баталж өгсөн гээд ингэж байгаа юм. Тэгээд ирэх жил Ерөнхийлөгчийн сонгууль болох гэж байдаг. Та бүхэн энэ жил төсөв батлагдаагүй гэдэг нэрээр ирэх жил Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө энэ хар машинуудаа актлагдчихсан машинуудаа гүйцээж шинээр авах тендер зарлах бэлтгэл ажлыг хангах ийм бололцоо боломж ер нь цаг хугацааны хувьд ямар байгаа юм бэ? Энийг бид нар онцгой анхаарахгүй бол дараа нь хариуцлага асуудал яригдвал хэн хариуцах вэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм.

Ийм 3, 4 асуудал дээр бид нар анхаарах асуудал байгаа. Тэгээд энэн дээр Даваа-Очир дарга бас нэг холбогдох хариулт тайлбарыг өгөөдхөөч. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Д.Даваа-Очир: Сандаг-Очир даргын асуултад хариулъя.

Сонгуулийн төв байгууллагын хуулиараа бол манай бүрэлдэхүүн 9 гишүүнтэй байдаг. 5 гишүүн нь бол ТББХ-оос сонгогддог, 2 нь бол Ерөнхийлөгчийн институтээс санал болгосноор, 2 нь бол Дээд шүүхээс санал болгож ингээд нийт 9 гишүүн. Үүний орон тооны гэдэг нь бол хорооны дарга, нарийн бичгийн дарга нь бол орон тооны гишүүд байдаг. Өнөөдрийн байдлаар бол Дэлгэрнараран дарга чөлөөлөгдсөн. Дэлгэрсайхан гишүүн чөлөөлөгдсөн. Ингээд 3 гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан.

Хоёр нь Ерөнхийлөгчийн санал болгосон, нэг нь Дээд шүүхийн санал болгосон. Үлдэж байгаа 4 гишүүн нь бол ямар ч байсан өнөөдөр бол хуулийн хугацаатай ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар бол 7 гишүүн бол үүргээ гүйцэтгээд явж байгаа. Түрүүн Сандаг-Очир дарга хэлсэн. Энэ асуудлыг ойрын хугацаанд шийдэж бүрэлдэхүүнийг нь бүтэн болгох ёстой гэж бид үзэж байгаа.

Санал тоолох төхөөрөмжтэй холбоотой асуудлыг ярьж байна. Би түрүүн Алтангэрэл гишүүний асуултад хариулахдаа хэлж байсан. Уул нь бид 2026 ондоо техникийнхээ бүрэн шинэчлэлийг явуулъя гээд үйлдвэрлэгч компанитайгаа яриад тендерээ зарлаад, бэлтгэл ажлаа хангаад ингээд явж байсан. Гэтэл маань улс орны хөрөнгө мөнгөний асуудалтай холбогдуулаад 30 хувийг нь өгсөн. Хэрвээ энэ ондоо техник шинэчлэлээ хийж чадахгүй бол ирэх оны 2027 оны сонгууль, 2028 оны сонгууль бол маш их эрсдэлтэй нөхцөл байдал үүснэ ээ.

Тийм учраас би үлдэж байгаа 29.1 тэрбум төгрөгийн асуудлыг хэрвээ төсвийн тодотголд ордог юм бол та бүхэн маань дэмжээд энэ асуудлыг шийдчихгүй бол Сонгуулийн хороо бол зүгээр нэг санал тоолох төхөөрөмж авчраад угсраад шууд санал авдаггүй. Энэ дээр бол маш их нарийн чимхлүүр ай ти-ийн холбогдох ажлууд явдаг учраас хүнээ сургана, техникээ хөрсөндөө буулгана, орон нутгийнхаа улсуудыг сургана. Нэг сонгууль явахад дунджаар бол 25 мянган төрийн албан хаагчид ажилладаг шүү дээ. Үүний бол 3-ны 1 нь Ай Ти-ийнхэн санал тоолох төхөөрөмжтэй ажилладаг улсууд байдаг. Эднүүсийгээ шинэ тоног төхөөрөмжтэйгөө сургана гэдэг бол бас бидний хувьд бол маш их өргөн далайцтай өргөн ажил болдог гэдгийг л манай гишүүд ойлгоосой гэж хүсэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хийсэн мэдээлэлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Зулпхар гишүүн.

С.Зулпхар: 3 санал байна. 1 дүгээрт угаасаа хуулийн хэрэгжилтийг хангуулах, сонгогчдын иргэдийн сонгох болон сонгогдох эрхтэй холбоотой энэ эрхийг нь хангуулах үүднээс Засгийн газар энэ сонгууль орон нутгийн сонгуультай холбоотой зардлыг бол Засгийн газрын нөөцөөс нөөц сангаас гаргаад угаасаа явах байх аа. Тэр ямар ч эргэлзээгүй. Хууль хэрэгжүүлэх үүрэг нь Засгийн газарт байгаа учраас тэрийг бид энд яах вэ мэдээлэл сонсоод энэ тэмдэглэлээр бас давхар очих байх гэж бодож байна.

Хоёр дахь зүйл бас сая ярьж байна. Энэ СЕХ-оос уг нь санал орж ирсэн шүү дээ. ТББХ-н дээр төсөв хэлэлцэх үед. Тэгээд сая Баярбаатар гишүүн ч гэсэн хэлж байна. Бид өөрсдөө энийг бол бүрэн харгалзаж чадахгүй болоод хасуулчихсан байхгүй юу. Бид бүгд ярьж байсан шүү дээ. Одоо энийг байх ёстой. Яагаад гэвэл иргэдийн сонгох, сонгогдох эрхтэй холбоотой энэ зохион байгуулалтыг хангах, бид сайн муу хэлж байгаа ч гэсэн хар машиныг чинь авчирч техникийн нөхцөлөөр бүрдүүлэх ёстой шүү дээ. Тэгээд энийг бол бид тухайн үед ингээд хасуулчихсан нь бол нэг талдаа Ариунзаяа гишүүний хэлдэгчлэн бид өөрсдөө бас анзаараагүйгээс болсон юм уу, эсвэл хариуцлагагүй байснаас болсон юм уу ийм л зүйл болсон.

Тэгэхээр одоо энийг бол төсвийн тодотгол орж ирэх бол шууд оруулж ирээд энийг бид заавал батлах ёстой. Тэгж байж энэ сонгогчдын сонгох сонгогдох эрхийг бүрэн хангах энэ хуулийн хэрэгжилт хангагдана аа. Тэгэхээр энэ дээр Сонгуулийн эрх хороо өөрсдөө ч гэсэн захиргааны түвшинд бас санаачилгатай та бүхэн ажиллаж мэдээллээр хангах, ойлгуулах ажил бас давхар хийгээд явна биз. Энэ ойлгох үүрэг нь бидэнд байгаа шүү дээ. Аливаа юмыг ер нь ойлгож мэдэх нь бидний үүрэг болохоос биш дараа нь араас нь бид мэдээгүй ойлгоогүй гэж ярих бол бидний бас өөрсдийн хариуцлагагүй асуудал болох байх гэсэн ийм бодолтой байна.

Гурав дахь зүйл энэ 3 дахь зүйл маш чухал. Анхнаасаа энэ аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийг сонгох тухай энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирэхдээ их зөвийг л бодож оруулж ирсэн байх. Гэхдээ энэ угаасаа судалгаа нь дутуу хийгдсэн байгаа байх. Тэгээд энэ хууль нь өөрөө Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуультай зөрчилдчихсэн. Тэгээд энийгээ аваачаад үүнийгээ ҮХЦ дээр аваачаад маргаан болгочихсон. ҮХЦ-ийн шийдвэр зөв шүү дээ. Нэг хууль нь хууль зөрчөөгүй бол нөгөөх нь зөрччихсэн л байгаа шүү дээ ойлгомжтой. Манай Сонгуулийн хууль чинь Үндсэн хуулиа зөрччихсэн байхгүй юу. Хэрвээ нөгөө хууль нь зөрчөөгүй бол нөгөөх нь зөрчсөн гэдэг нь бараг ямар ч логигоор тодорхой байгаа. Тэгэхээр зэрэг одоо бол яах яах вэ хүчин төгөлдөр үйлчилж байгаа хурлаар энэ сонгууль болдогтоо болно. Нөхөн сонгуулиуд бол.

Цаашдаа ийм байдал гаргуулахгүйн тулд би Ариунзаяа гишүүнтэй санал нэг байна. Баярбаатар гишүүнтэй санал нэг байна. Бид санаачлаад энэ хуулийн төслөө оруулъя. Бүгдээрээ одоо жишээ нь ялангуяа та бид 3 энд Уянгахишиг гишүүн байна, Хэрлэн гишүүн байна. Бид нар ярьж байгаад энэ чиглэлийн юмнуудыг наана уу, цаана уу бас гадарладаг улсууд судалгааг нь хийдэг улсууд бол яаралтай оруулаад энэ хуулийн зөрчлийг гаргаж авъя аа. Энэ ҮХЦ дээр аваачиж заавал нэг зөрчилтэй эсэхийг шийдвэр гаргуулж байж араас нь бид нар явдаг нэг ийм хууль тогтоогч нар

байж болмооргүй байгаа байхгүй юу. Анхнаасаа хуулиа оруулахдаа зөв оруулаад судалгаагаа зөв хийгээд тэгээд явмаар байна. Хэний хүслийг биелүүлэх гэж орсон юм, ямар жишээ нь зорилго биелүүлэх гэж орсон юм би бүүр гайхаад байгаа байхгүй юу. Маш ойлгомжтой шүү дээ. Нэгэн зэрэг 2 өөр чиг үүрэгтэй хуралд нэгэн зэрэг сууна гэдэг ийм хуулийн төсөл оруулж ирж байсан тэр улсуудыг зүгээр бодоход бол та нөхөд маань хариуцлагагүй байжээ л гэж хэлмээр байна.

Цаашдаа ийм хууль бид байж ерөөсөө болохгүй байх гэж бодож байна. Тэгээд СЕХ-ныхон та бүхэн маань бас мэдээж хэрэг та бүхэнд сонгуулийн олон хугацааны сонгуулийн туршлага байж байгаа. Цааш цаашдаа энэ сонгуультай холбоотой зүйл дээр бол та бүхнийгээ бид бас мэргэшсэн түвшинд бидэнд зөвлөгөө өгөх гол л жишээ нь институт гэж ойлгож байгаа шүү дээ. Та нарын жишээ нь санал зөвлөгөөгөөр бид бас явах ёстой. Тэгж байж энэ бол сонгууль сонгуультай холбоотой, сонгуулийн зохион байгуулалт гол үндсэн асуудал болсон сонгогчдын иргэд нь шүү дээ. Сонгох сонгогдох эрхийн асуудлыг бид бүрэн хангахтай холбоотой. Энэ бүх зүйлийг эрх зүйн болон зохион байгуулалтын асуудлыг. Одоо баараагүй хийдэг болох юм байна л гэж ойлгож байгаа юм. Үндсэндээ бол манай СЕХ сайн ажиллаж байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Би бас протоколд үлдээх байдлаар үгээ үлдээе. Тэр өнгөрсөн онд төсөв хэлэлцэж байх үед санал гаргасан гишүүн нь би байгаа юм.

Энэ СЕХ-ны санал тоолох машиныг шинэчлэх төсвийг бүх төсвийн ерөнхийлөн захирагчдаас 0.03 хувийг танаад тэгээд энэ санал тоолох машиныг шинэчилж гэдэг саналыг гаргаад тэгээд улаан лаазаар унагасан юм. Улаан лааз өргөж байгаад. Уул нь Байнгын хороо дэмжээд оруулсан. Тэгээд Байнгын хорооны санал нэгдсэн чуулган дээр улаан лаазанд унасан юм. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр СЕХ-ныхон Бум-Очир гишүүнтэй хамтраад Ерөнхийлөгчийн хуулиа хэлж байгаа бол тэр хууль дээр бараг санал тоолох машинаар биш гараар тоолно гээд оруулчихсан нь зөв байх аа.

Одоогийн энэ санал тоолох машинууд чинь ажиллахгүй, нэгд.

Хоёрт ажилласан ч иргэд итгэхгүй итгэхгүй. Наад машин чинь тэгээд 1 дэлгүүрт зарж байгаа юм шиг бэлэн байдаггүй юм байна лээ. Тэдэн ширхэг хэрэгтэй гээд захиалахаар хамгийн багадаа 11 сар гэсэн байхгүй юу. Хамгийн багадаа гарахад 11 сар. Өнөөдөр чинь хэдэн сар билээ. Ирэх жилийн 6 сард хэрэглэнэ шүү дээ бид нар. 12 сар, 13 сар дутуу байна. Өнөөдөр төсвийн тодотгол ороод мөнгө нь гарч ирээд захиалга өгч байвал амжих юм байна. Энэнээс хойш амжихааргүй.

Тэгэхээр энийг би бүүр зориудаар протоколд үлдээе. Энэ тухайн үед нь Зулпхар гишүүн хэлж байна. Бид зөндөө тайлбарлаж ярьсан байхгүй юу. Бүүр энэ хугацааг нь яриад. Одоо бид нар ингээд төсөвт суулгаж байж он гарангуут захиалбал ирэх жилийн 11 сард эхнийх нь орж ирэх юм байна аа. Тэгж байж тэрийг бэлтгэл ажил хангуулж байж тэрний дараагийн 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд бас ашиглана. Энэ чинь шууд оруулаад ирэнгүүт нь ингээд принтер асааж байгаа юм шиг бас асаачихдаггүй юм биш юм байна. Энэчээ чинь бас тодорхой түвшинд ингээд нөгөө бэлтгэл ажил хангуулна гээд бас 1, 2 сар программ гээд ингээд явдаг.

Тэгэхээр өнөөдөр бид нар төсөвгүй байгаа тохиолдолд энэ ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуульд мэдэхгүй. Дээр нь СЕХ сайн ажиллаж байгаа. Тэгэхдээ та хэд маань өнөөдрийн байгаа санал тоолох төхөөрөмждөө бас яг энэ ирэх жилийн сонгуулийг бүрэн зохион байгуулчих тийм бүрэн итгэлгүй байгаа гэдгийг би мэдэж байгаа шүү итгэлтэй байна гэж бас битгий хамаагүй яриарай. Юм үнэнээрээ дээр. Энэ тулгамдаад байгаа асуудлуудаа бид нар ингээд шийдэхгүйгээр тэгээд тэр төсөв унаад л тэгээд л хаашаа орсон гэлээ ноднин чинь төсөв батлагдах үед чинь нөгөө эрхтэн шилжүүлэх төвийн барилгын мөнгийг авч байгаад зам руу хийчихсэн. Уйлаан болж байгаад нэг наана цаана олгож байгаад Ерөнхийлөгчийн санаачилгаар ч билүү бараг буцааж нэг дуусгахаар болсон. Одоо энэ санал тоолох машины мөнгө бас уул нь худалдаж авна гээд л тэгсэн тэгээд л байхгүй болчихсон. Одоо тэгээд 2027 оны төрийн тэргүүнээ сонгох сонгуулиа яаж зохион байгуулах юм. Надад бол жоохон бүрхэг л санагдаж байгаа юм. Энд манай СЕХ яаж ч хичээгээд ажиллаад тэр чинь тоног төхөөрөмж, программ гэдэг зүйл чинь хүнээс шалтгаалахгүй хараат бус зүйл шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас гишүүнтэй бас санал нэг байна. Хуулиа санаачлаад өргөн бариад явъя. Одоо энэ сонгуулийн хугацаа нь дөхөж байгаа үед аль болох бид нар судалгаатай шинжлэх ухаанд суурилсан асуудлуудыг Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг тухайн үедээ баталж байсан хүмүүс гэдэг юм уу энэ хууль дагаж өргөн мэдүүлэх ёстой байсан хуулийг орхигдуулсан буюу ингээд хуулийн зөрчилдөөн үлдээчихсэн юм байна аа. Одоо чиний муу энэ миний буруу гээд ч яах вэ? Нөхцөл байдал нэгэнтээ ийм байна. Яг одоо 2 шатдаа сонгогдчихсон байгаа хүмүүс дээр хууль алаг цоог үйлчилж байгаа буюу СЕХ тухайн одоо нэгжийн иргэдийн хуралд саналаа хүргүүлээд тухайн иргэдийн хурал нь өөрөө бас шийдвэрлэж байгаа юм байна гэж түрүүн хэлсэн. Зарим газраа давхар үлдэж байгаа юм байна. Зарим газар хүчингүй болгоод нөхөн сонгогдчихсон юм байна. Зарим газар нь нөхөн сонгууль зарлагдах гээд явж байна аа.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэвэл нь түрүүн яаралтайгаар яагаад хуулийн өөрчлөлтийг хийж болох вэ үгүй вэ гэж би асуусан нь бол одоо нөхөн сонгууль зарлахад нөгөө хуулийн зөрчил хэвээрээ байх болчихоод байгаа учраас эргээд л дахиад л нөгөө хүн хүний эрх зөрчигдөх л байхгүй юу даа. Хуулиар нь нээлттэй байгаад байдаг. Гэтэл эрхийг нь ингээд хаагаад байдаг. Тэгээд нөхөн сонгууль зарлачихсан байгаад байна. Дэг бас л ингээд л нөгөө хүний эрх зөрчигдөж байгаа асуудал мөн үү мөн.

Хуулийг яаралтайгаар өргөн барих боломж нь юу байсан бэ гэхлээр Дэгийн тухай хуулийн 87.2-т цэцийн тогтоолыг хүлээн авсан бол 15 хоногийн дотор энэ хуулийн зөрчлийг арилгана гээд. Хамгийн гол асуудал нь юу вэ гэхээр тухайн энэ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль нь өөрөө Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэсэн дүгнэлт гарчихсан байгаа байхгүй юу. Гэтэл орон нутгийн энэ Сонгуулийн тухайлсан тэр заалт нь өөр өөрөө бас Үндсэн хууль зөрчсөн юм уу үгүй юм уу гэдэг дээр ҮХЦ зөрчсөн байна гэдэг шийдвэр гаргана гэдэг үг бас биш бас биш.

Тухайлсан заалт дээр зөрчөөгүй ч гэж гарч болно. Тэгэхээр энэ бол өөрөө маш ийм тийм ярвигтай асуудал болчихоод байгаа нь бол ингээд л дахиад л нөгөө

хууль тогтоогчдын л буруу болчхоод байгаа байхгүй юу. Бодлогын хувьд яах ёстой юм бэ гэдгийгээ энэ танхимд байгаа болон энэ хүмүүс л тогтох ёстой болчхоод байна аа.

Тэгэхээр хуулийг яаралтай өргөн барих эрх нь Улсын Их Хурлын гишүүдэд байдаггүй байхгүй юу. Яах вэ магадгүй Засгийн газарт байгаа. Ийм учраас миний санал юу байна вэ гэхлээр СЕХ-ны мэдээлэл сонссонтой холбогдуулан ТББХ-ны тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөх ийм асуудлыг оруулж ирж дараагийн хуралдаанаар оруулж ирж баталъя. Тэгээд тэр нь юу байх юм бэ гэхээр 1 дүгээрт дүгээрт энэ хуулийн зөрчлийг яаралтай арилгах яаралтай горимоор хуулийн тухайлсан тэр заалтыг өргөн барьж зөрчлийг арилга.

Хоёрт энэ асуудлыг шийдвэрлэх 814 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлэ.

Гуравт 29.1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх тэр төсвийг энэ жилдээ төсвийн тодотгол хийхээр бол зайлшгүй шийдвэрлэ гэдэг ийм үүрэг даалгавар бүүр чиглэлийг ТББХ-оос Засгийн газарт өгмөөр байгаа байхгүй юу албажуулаад. Тэгж байж бид сая үүнийгээ нэхэн шаардах энэ боломж нь үүсэх болов уу гэж бодож байна. СЕХ-ны өгсөн төсвийн саналыг Сангийн яам тухайн үед төсвөө боохдоо орхигдуулаад л гаргачихсан байхгүй юу даа. Тэгээд Баярбаатар эндээ зарчмын зөрөөтэй санал гаргаж ТББХ дэмжсэн ч гэсэн чуулганы хуралдааны явцад болон Төсвийн байнгын хорооны төсвийн ажлын хэсэг дээр энэ бол орхигдоод ингээд явсан байна.

Ийм учраас хуулийн энэ асуудлыг хуулийн энэ гарц гаргалгаагаараа л бид нар шийдэх учраас ТББХ-оос Засгийн газарт чиглэл өгөх тогтоол дараагийн хуралдаанаар баталъя. Тэгээд тогтоол боловсруулах санал санаачилгыг болохгүй л би аваад явъя.

Гишүүд үг хэлж дууслаа.

Ер нь нөгөө хяналт шалгалтын хуулиар Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгөхийг хориотой. Яах вэ Их Хурлын тогтоолоор өгч болно. Яах вэ бид нар өнөөдрийн хуралдаанаас протоколоор Засгийн газарт албан бичгээр өгч болно. Таны яг саяын дурдсан 3 асуудлаар. Төсөвтэй холбоотой хуулийг шинэчлэх яаралтай. Тэр яах вэ өөрсдөө бид Их Хурлын гишүүдийн асуудал. Ер нь гол нь төсвийн асуудал байгаа ЗГ-аас шийдүүлэх нь бол. Энэ асуудлаар Засгийн газарт тэгээд нөгөө хар машинтай холбоотой шинэчлэхтэй холбоотой төсвийн асуудал гээд энэ 2 төсвийн асуудлыг Засгийн газарт өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэлэлцсэн асуудлыг протоколоор чиглэл өгч болно оо.

Ер нь бол тэгэх нь зүйтэй. Тэгэхгүй бол цаг хугацаа бас нэлээн оройтчихсон байна аа. Тийм учраас тулчихсан байна. Тийм учраас ингэж явъя гэж ингэж бодож байна. Тэгээд ажлын алба гишүүдийн хэлсэн протокол дээр төсөв санхүүтэй холбоотой энэ протоколоор Засгийн газарт чиглэл өгөөд явчихъя гэж ингэж бодож байна аа. Ингээд СЕХ-ноос ИТХ-ын нөхөн сонгуулийн явцын талаар хийсэн мэдээллийг сонсож дууслаа.

Өнөөдрийн ТББХ-оор хэлэлцэх асуудал дууслаа.

Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

11.05 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА